



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ, 2025

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг тус тус баталсан. Төлөвлөгөөнд 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 24 үр дүн, хөтөлбөрийн 53 үр дүн, 194 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлт тусгагдсан.

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлогын биелэлтийг сайжруулах, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Үндэслэл, арга зүй

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.”, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 “хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, Засгийн газарт танилцуулах” заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн биелэлт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөгөөнд тусгагдсан 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хамаарах 194 төсөл, арга хэмжээний биелэлтийг урьдчилан тодорхойлсон 205 шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж, хүрсэн түвшинг тоогоор илэрхийлсэн бол дээрх журмын 6.2.1-т заасан аргачлалаар, тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй тохиолдолд журмын 6.2.2-т заасан аргачлалаар тус тус үнэлж, төлөвлөгөөний биелэлтийг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

3.1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг тэргүүлэх 8 чиглэл, 23 зүйл, 38 дэд зүйлтэйгээр баталсан бол тогтоолын хоёрдугаар хавсралтаар дээрх нэгдүгээр хавсралтад дурдсан тэргүүлэх чиглэлийг хангах төлөвлөгөөг баталсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнг, тэдгээрийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд тулгуурлан тооцов.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төлөвлөгөөний биелэлт дунджаар 57.2 хувь байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 19.1 хувь буюу 37 арга хэмжээ “үр дүнтэй”, 30.9 хувь буюу 60 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 35.1 хувь буюу 68 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 14.9 хувь буюу 29 арга хэмжээ “үр дүнгүй” хэрэгжсэн байна.

Зураг 1. “Бодлогын тэргүүлэх чиглэл”-ийн үндсэн зорилтын хэрэгжилт



Хүснэгт 1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт (тэргүүлэх чиглэлээр)

№	Тэргүүлэх чиглэл	ТЭЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Арга хэмжээний тоо				Биелэлт (хувиар)
					Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
1	Экспортыг нэмэгдүүлнэ	4	6	23	1	6	8	8	36.5
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	5	11	52	1	11	19	12	50.2
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	3	11	28	7	12	6	3	71.4
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	3	3	35	4	5	23	3	45.0
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна	1	1	5	-	4	1	-	78.0
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна	2	7	23	4	9	7	3	59.9
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна	5	10	20	6	11	3	-	81.0
8	Ногоон хөгжлийг дэмжинэ	1	4	8	5	2	1	-	86.3
Нийт		24	53	194	37	60	68	29	
Нийт дүнд эзлэх хувь				100	19.1	30.9	35.1	14.9	

Төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэлийн биелэлтийг харьцуулан авч үзэхэд, “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэл 86.3 хувь, “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэл 81.0 хувь байгаа нь бусад тэргүүлэх чиглэлээс илүү өндөр хувьтай байна.

3.1.1. “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 үр дүн, хөтөлбөрийн 6 үр дүн, 23 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 36.5 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 14.7 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үнэлгээ

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний тоо				Биелэлт (хувиар)
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
				100	99-70	69-30	29-0	
1.1	Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ	2	11	-	2	4	5	25.5
1.2	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ	1	5	-	1	3	1	36.0
1.3	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ	2	5	1	2	1	1	62.0
1.4	Гадаад худалдааг хөнгөвчилнө	1	2	-	1	-	1	35.0
Нийт дүн		6	23	1	6	8	8	
Нийт дүнд эзлэх хувь			100	4.3	26.1	34.8	34.8	

Дээрх тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 үр дүнгийн биелэлтийн дундаж 39.6 хувь байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, “Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ” үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 11 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 25.5 хувь, “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ” хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 36.0 хувь, “Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт 62.0 хувь, “Гадаад худалдааг хөнгөвчилнө” хүрээнд 2 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 35.0 хувь байна.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 6 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 40.4 хувь байна.(Хавсрал 1)

Дээрх 6 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 23 төсөл, арга хэмжээнээс 1 арга хэмжээ буюу 4.3 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 6 арга хэмжээ буюу 26.1 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 8 арга хэмжээ буюу 34.8 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 8 арга хэмжээ буюу 34.8 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна. (Хавсралт-2)

“Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс дараах 8 төсөл, арга хэмжээ “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувиар үнэлэгдсэн байна:

- 1.1.2.2.Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих;
- 1.1.2.3.Налайх-Замын-Үүд чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх;
- 1.1.2.4.Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх;
- 1.1.2.5. Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам барих;
- 1.1.2.6.Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Улиастай-Алтай чиглэлийн 42 км авто зам барих;

- 1.2.1.5.Цагаандэл-Уул хилийн боомтын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэх;
- 1.3.1.2.Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх;
- 1.4.1.2.Гадаад худалдааны явцад бүрдүүлдэг баримт бичгийн давхардлыг арилгах.

3.1.2.“Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүн, хөтөлбөрийн 11 үр дүн, 52 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 50.2 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 4.1 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3.“Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дүнгийн үнэлгээ

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөр-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь				Дундаж хувь
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
2.1	Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	3	9	0	4	2	3	47.8
2.2	Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	3	16	1	3	11	1	47.5
2.3	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	2	18	7	3	2	6	55.0
2.4	Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	2	7	2	1	2	2	47.9
2.5	Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	1	2	0	0	2	0	47.5
Нийт дүн		11	52	10	11	19	12	
Нийт дүнд эзлэх хувь			100	19.2	21.2	36.5	23.1	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, “Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ” хүрээнд 9 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 47.8 хувь, “Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” хүрээнд 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 47.5 хувь, “Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” хүрээнд 18 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 55.0 хувь, “Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна” хүрээнд 7 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 47.9 хувь, “Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна” хүрээнд 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 47.5 хувьтай байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 11 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 49.5 хувь байна. (Хавсрал 1)

Дээрх 11 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 52 төсөл, арга хэмжээнээс 10 арга хэмжээ буюу 19.2 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 11 арга хэмжээ буюу 21.2 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 19 арга хэмжээ буюу 36.5 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 12 арга хэмжээ буюу 23.1 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна (Хавсралт 2).

“Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс дараах 12 төсөл, арга хэмжээ “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувиар үнэлэгдсэн байна:

- 2.1.1.1.Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг үзүүлэх;
- 2.1.1.4.Төрөөс бизнесийн үйл ажиллагаанд хийх давхардсан хяналт шалгалтыг бууруулах;
- 2.1.2.1.Банкны салбарын реформыг хэрэгжүүлж, гадаадын банкны салбар байгуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- 2.2.3.3.Гангийн үйлдвэр байгуулах;
- 2.3.2.1.Тавантолгойн 300+150 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх;
- 2.3.2.2.Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 325 МВт-аар өргөтгөх;
- 2.3.2.3.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх;
- 2.3.2.7.Багануурын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх;
- 2.3.2.11.Эрдэнэбүрэн-Мянгадын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих;
- 2.3.2.12. Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих;
- 2.3.2.16.Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 МВт-аар өргөтгөх;
- 2.4.1.2.Монгол кино үйлдвэрийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн төв болгох;
- 2.4.2.5.Үндэсний урлагийн их театрын шинэ барилгыг барих.

3.1.3. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүн, хөтөлбөрийн 11 үр дүн, 28 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 71.4 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 14 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 4. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дүнгийн үнэлгээ

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь					Биелэлт хувиар
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
				100	99-70	69-30	29-0		
3.1	Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	5	12	4	5	3	0	78.3	
3.2	Нийгмийн баталгааг сайжруулна.	3	4	1	3	0	0	92.5	

3.3	Өвчлөл, нас баралтыг бууруулна.	3	12	2	4	3	3	57.5
	Нийт дүн	11	28	7	12	6	3	
	Нийт дүнд эзлэх хувь		100	25.0	42.9	21.4	10.7	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, “Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна” хүрээнд 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 78.3 хувь, “Нийгмийн баталгааг сайжруулна” хүрээнд 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 92.5 хувь, “Өвчлөл, нас баралтыг бууруулна” хүрээнд 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 57.5 хувь байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 11 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 77.0 хувь байна. (Хавсрал 1)

Дээрх 11 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 28 төсөл, арга хэмжээнээс 7 арга хэмжээ буюу 25.0 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 12 арга хэмжээ буюу 42.9 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 6 арга хэмжээ буюу 21.4 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 3 арга хэмжээ буюу 10.7 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна. (Хавсралт 2)

“Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 7 төсөл, арга хэмжээ 100 хувь буюу “үр дүнтэй” үнэлэгдсэн бол 3 төсөл, арга хэмжээ “үр дүнгүй” буюу 0-30 хүртэл хувиар үнэлэгдсэн байна:

- 3.3.2.”Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд:
- 3.3.2.2.Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга барих;
- 3.3.2.3."Хавдар судлалын үндэсний төвийн салбар II"-ын барилга барих;
- 3.3.2.4. Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих.

3.1.4.“Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүн, хөтөлбөрийн 3 үр дүн, 35 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 45.0 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 17.4 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 5. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгээр

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь				Дундаж хувь
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлага тай	Үр дүнгүй	
				100	99-70	69-30	29-0	
4.1	Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ	1	5	2	0	2	1	52.0
4.2	Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ	1	5	0	1	4	0	42.0
4.3	Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	25	2	4	17	2	44.2
	Нийт дүн	3	35	4	5	23	3	
	Нийт дүнд эзлэх хувь		100	11.4	14.3	65.7	8.6	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, “Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ” хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 52.0 хувь, “Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ” хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 42.0 хувь, “Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” хүрээнд 25 төсөл, арга хэмжээний биелэлт 44.2 хувьтай байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 3 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 46.1 хувь байна. (Хавсралт 1)

Дээрх 3 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 35 төсөл, арга хэмжээнээс 4 арга хэмжээ буюу 11.4 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 5 арга хэмжээ буюу 14.3 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 23 арга хэмжээ буюу 65.7 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 3 арга хэмжээ буюу 8.6 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна. (Хавсралт 2)

“Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс дараах 3 төсөл, арга хэмжээ үр дүнгүй буюу 0.0-30.0 хүртэл хувиар үнэлэгдсэн байна:

“Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.” хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд:

- 4.1.1.4.Палеонтоло-гийн нөөцөд тулгуурлан "Аялал-Судалгаа-Амралт"-ын цогцолбор байгуулах /Дундговь, Цагаан суварга/;
- 4.3.1.21.Баруун-Урт- Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих /Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум/;
- 4.3.1.22.Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих;

3.1.5.“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 үр дүн, хөтөлбөрийн 1 үр дүн, 5 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 78.0 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 46 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 6. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үнэлгээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь				
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж хувь
				100	99-70	69-30	29-0	
5.1	Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	1	5	0	4	1	0	78
Нийт дүн		1	5	0	4	1	0	
Нийт дүнд эзлэх хувь			100	0.0	80	20	0	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 1 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 78.0 хувь байна. (Хавсралт1)

Дээрх 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 төсөл, арга хэмжээнээс 4 арга хэмжээ буюу 80.0 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 1 арга хэмжээ буюу 20.0 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн байна. (Хавсралт 2)

3.1.6. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2 үр дүн, хөтөлбөрийн 7 үр дүн, 23 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 59.9 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 11.7 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 7. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үнэлгээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь				Дундаж хувь
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
6.1	Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна	4	15	3	3	6	3	50.5
6.2	Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ	3	8	1	6	1	0	77.5
Нийт дүн		7	23	4	9	7	3	
Нийт дүнд эзлэх хувь			100	17.4	39.1	30.4	13	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, “Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна” хүрээнд 15 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 50.5 хувь, “Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” хүрээнд 8 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 77.5 хувь байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 7 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 66.3 хувь байна.(Хавсралт 1)

Дээрх 7 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 23 төсөл, арга хэмжээнээс 4 арга хэмжээ буюу 17.4 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 9 арга хэмжээ буюу 39.1 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 7 арга хэмжээ буюу 30.4 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 3 арга хэмжээ буюу 13.0 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн байна. (Хавсралт-2)

“Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс дараах 3 төсөл, арга хэмжээ үр дүнгүй буюу 0.0-30.0 хүртэл хувиар үнэлэгдсэн байна. Үүнд:

“Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд:

- 6.1.3.4.Нийслэлд тусгай замын автобусны сүлжээ байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх /BRT/;
- 6.1.3.6.Цахилгаан автобус цэнэглэх өндөр хүчин чадалтай станц барих;

- “Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно” хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд;
- 6.1.4.2.Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох Наадамчдын гудамжны 800 у/м гүүр барих зэрэг орж байна;

3.1.7. “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүн, хөтөлбөрийн 10 үр дүн, 20 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 81.0 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 28.9 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 8. “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үнэлгээ

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн		Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь				Дундаж хувь
					Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
7.1	Авлигын сайжруулна	үзүүлэлтийг	1	2	2	0	0	0	100
7.2	Төрийн дээшлүүлнэ	бүтээмжийг	5	10	1	7	2	0	73
7.3	Хүний эрхийн бууруулна	зөрчлийг	1	2	0	2	0	0	80
7.4	Батлан хамгаалах бэхжүүлнэ	чадавхыг	2	3	1	1	1	0	80
7.5	Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ		1	3	2	1	0	0	96.7
Нийт дүн			10	20	6	11	3	0	
Нийт дүнд эзлэх хувь				100	30	55	15	0	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, “Авлигын үзүүлэлтийг сайжруулна” хүрээнд 2 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 100.0 хувь, “Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ” хүрээнд 10 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 73 хувь, “Хүний эрхийн зөрчлийг бууруулна” хүрээнд 2 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 80 хувь, “Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ” хүрээнд 3 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 80 хувь, “Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ” хүрээнд 3 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 96.7 хувьтай байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 10 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 81.8 хувь байна. (Хавсралт 1)

Дээрх 10 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20 төсөл, арга хэмжээнээс 6 арга хэмжээ буюу 30.0 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 11 арга хэмжээ буюу 55.0 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 3 арга хэмжээ буюу 15.0 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай байна. (Хавсралт 2)

3.1.8 “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 үр дүн, хөтөлбөрийн 4 үр дүн, 8 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 86.3 хувь байгаа ба эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад 48 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 9. “Ногоон хөгжлийг дэмжих” бодлогын тэргүүлэх чиглэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үнэлгээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь				Дундаж хувь
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
8.1	Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална	4	8	5	2	1	0	86.3
	Нийт дүн	4	8	5	2	1	0	
	Нийт дүнд эзлэх хувь		100	62.5	25	12.5	0	

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 4 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 78.8 хувь байна. (Хавсралт 1)

Дээрх 4 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8 төсөл, арга хэмжээнээс 5 арга хэмжээ буюу 62.5 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 2 арга хэмжээ буюу 25.0 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 1 арга хэмжээ буюу 12.5 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай байна. (Хавсралт 2)

3.2. Санхүүжилтийн гүйцэтгэл

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 194 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлтийг 13.994.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 5.099.9 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 36.4 хувийг эзэлж байна.

Нийт 194 төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн дүнг төлөвлөгөөнд тусгаагүй 9 төсөл, арга хэмжээ байна. Харин гүйцэтгэлээр 96 төсөл, арга хэмжээ 2024 оны жилийн эцэст санхүүжилт авсан байна.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний 194 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр авч үзэхэд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 120 төсөл, арга хэмжээнд 2.224.6 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 67 төсөл, арга хэмжээнд 2.652.4 сая төгрөг;
- Улсын төсөв, гадаадын зээлээр 4 төсөл, арга хэмжээнд 441.4 тэрбум төгрөг төлөвлөж санхүүжилт хийгдээгүй;
- Улсын төсөв, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар 1 шалгуур үзүүлэлтэд 83.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс санхүүжилт хийгдээгүй;
- Улсын төсөв, гадаадын тусламжаар 1 төсөл, арга хэмжээнд 65.3 тэрбум төгрөгийг төлөвлөж санхүүжилт хийгдээгүй;
- Гадаадын зээл, тусламжаар 23 төсөл, арга хэмжээнд 1.386.8 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 13 төсөл, арга хэмжээнд 1.003.9 сая төгрөг;
- Төр-хувийн хэвшлийн түншлэлээр 6 төсөл, арга хэмжээнд 4.520.7 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 төсөл арга хэмжээнд 160.0 тэрбум төгрөг;
- Орон нутгийн төсвөөр 16 төсөл, арга хэмжээнд 99.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 6 төсөл арга хэмжээнд 652.3 тэрбум төгрөг;
- Орон нутгийн төсөв, гадаадын зээлээр 2 төсөл, арга хэмжээнд 148.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс санхүүжилт хийгдээгүй;

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 9 төсөл, арга хэмжээнд 3.436.0 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 5 төсөл, арга хэмжээнд 474,162.0 сая төгрөг;
- Бусад эх үүсвэрээр 12 төсөл, арга хэмжээнд 1,589.0 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 3 төсөл, арга хэмжээнд 157.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Эх үүсвэр шийдэгдээгүй 1 төсөл арга хэмжээ гүйцэтгэлээр 32.0 сая төгрөг гарсан байна.

Хүснэгт 10. Төсөл, арга хэмжээний санхүүжилт, эх үүсвэр

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөсөн		Гүйцэтгэл	
		Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн /тэрбум.төг/	Төсөл, арга хэмжээ	Зарцуулсан /тэрбум.төг/
1	Улсын төсөв	120	2,224.60	61	2,652.42
2	Улсын төсөв, гадаадын зээл	4	441.38		0
3	Улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	83.68		0
4	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	1	65.38		0
5	Гадаадын зээл, тусламж	23	1,386.85	13	1,003.97
6	Төр-хувийн хэвшлийн түншлэл	6	4,520.79	1	160
7	Орон нутгийн төсөв	6	99.00	6	652.29
8	Орон нутгийн төсөв, гадаадын зээл	2	147.99		0
9	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	9	3,435.96	5	474.16
10	Бусад эх үүсвэр	12	1,589.04	3	157.06
11	Эх үүсвэр төлөвлөөгүй	0	0	1	0.032
Нийт		184	13,994.65	96	5,099.93

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Төлөвлөгөөнд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээгээр санхүүжилтийн гүйцэтгэлийг харвал 10 төрлийн эх үүсвэрээс 13.994.7 тэрбум төгрөгөөр төгрөгийн санхүүжилтийг төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 7 төрлийн 96 төсөл, арга хэмжээнд 5.099,9 тэрбум төгрөгөөр санхүүжсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 67 төсөл, арга хэмжээ нийт зарцуулсан санхүүжилтийн 52 хувь, гадаадын зээл тусламжаар 13 төсөл, арга хэмжээ нийт зарцуулсан санхүүжилтийн 19.7 хувь, төр хувийн хэвшлийн түншлэлээр 1 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 3.1 хувь, орон нутгийн төсвөөр 6 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 12.8 хувь, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар 5 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 9.3 хувь, бусад эх үүсвэрээр 3 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 3.1 хувь, эх үүсвэр тавьж өгөөгүй 1 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 0.0006 хувийг тус тус эзэлж байна. Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувьд төрийн захиргааны төв байгууллагууд болон холбогдох байгууллагууд мөнгөн дүнг сая төгрөгөөр илэрхийлэхээр заасан боловч тэрбум төгрөг, мянган төгрөг, төгрөг эсхүл орон алдсан гэх мэт нарийвчлалгүй буруу тайлагнах, зарцуулсан санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус эсхүл дурдаагүй байсныг тодруулж тайлагнасан.

Төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэгч яамдаар авч үзвэл Гэр бүл нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам Боловсролын яам, Хот байгуулалт барилга орон сууцны яам, Батлан хамгаалах яам 70.0 дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 2. Хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж үзүүлэлт (яамдаар)



Хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байдлыг хэрэгжүүлэгч байгууллагаар нь авч үзвэл, Хууль зүй, дотоод хэргийн яам-Авлигатай тэмцэх газар, Боловсролын яам-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсролын яам- Хууль зүй, дотоод хэргийн яам-Монгол Улсын Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-Стандарт, хэмжил зүйн газар, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороо зэрэг байгууллагуудын хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ нь 70.0 дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 3. Хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж үзүүлэлт (хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар)



3.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшин

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг тус тус баталсан. Тус хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийт 85 зорилтот үр дүнгийн 100 шалгуур үзүүлэлт тусгагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн мэдээллийн эх сурвалж болох 31 байгууллага, мөн мэдээллийг тайлагнах төрийн 27 байгууллагыг тус тус заасан байна.

Нэг. Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд Экспортыг нэмэгдүүлэх, Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, Аялал жуулчлалыг хөгжүүлэх, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, Засаглалын үзүүлэлтийг сайжруулах, Ногоон хөгжлийг дэмжих зэрэг 8 чиглэлийн 23 зорилт, 39 дэд зорилтыг хэрэгжүүлэхээр тусгаж, тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 8 шалгуур үзүүлэлтийг баталсан.

Дээрх 8 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшинг тодорхойлсон бол 2 шалгуур үзүүлэлтийг өмнөх 2023 оны үзүүлэлтээр тооцсон, 2 шалгуур үзүүлэлтийг хүрсэн түвшинг тодорхойлох боломжгүй байна. Нийт 6 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үзүүлэлт дунджаар 48.3 хувь байна. (Хавсралт 1)

Тэргүүлэх чиглэл бүрээр үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг авч үзвэл:

- “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнг “экспорт” гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлж байгаа бөгөөд Үндэсний статистикийн хорооны 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр энэ үзүүлэлт 15.8 тэрбум ам. доллар байгаа нь төлөвлөсөн зорилтот түвшингээс 13.2 хувиар илүү хэрэгжсэн байна.

- “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнг гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр тодорхойлж байгаа бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яамны гаргасан статистик мэдээллээр 2024 онд 2.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байгааг суурь болон төлөвлөсөн зорилтот түвшинтэй харьцуулж тооцоход, гүйцэтгэл 15.4 хувь байна.

- “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт нь Хүний хөгжлийн үзүүлэлт бөгөөд энэхүү үзүүлэлтийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Хүний хөгжлийн үзүүлэлтийн 2023-2024 оны тайлан”-ийн дүнгээс авч үзэхэд, Монгол Улсын эрэмбэ 96 дугаар байранд байгаа бөгөөд энэ нь суурь түвшингээс ахиагүй байна. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо нь хүний хөгжлийн индексийг дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох ҮНО-ын индекс гэсэн бүрэлдэхүүн индексээр тооцдог ба 2023 оны байдлаар хүний хөгжлийн индекс 0.788 байна.

- “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнг хүлээн авах гадаад жуулчдын тоо гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлж байгаа бөгөөд 2024 онд 1.3 сая гадаадын жуулчдыг хүлээн авсан байхаар төлөвлөсөн. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр улсын хилээр орсон жуулчдын тоо 727.4 мянга байгаа ба үүнийг суурь болон зорилтот түвшний үзүүлэлттэй харьцуулахад, 43.0 хувь байна.

- “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнг Хүнсний аюулгүй байдлын индекс гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлохоор

төлөвлөсөн ч уг үзүүлэлтийг тооцох аргачлал, тоон үзүүлэлт нь батлагдаагүй учир шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох боломжгүй байна.

- “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнг Хотын хөгжлийн үзүүлэлт гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлохоор төлөвлөсөн бөгөөд 2024 оны үзүүлэлт нь 2025 оны 6 сард гарах тул 2023 оны үзүүлэлтийг авч үзэв. Энэхүү үзүүлэлтийн 2023 оны хүрсэн түвшин 0.5022 оноо ба зорилтот түвшинтэй харьцуулахад, хүрсэн түвшний гүйцэтгэл 83.7 хувь байна.

- “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнг Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж үзүүлэлтээр тодорхойлохоор төлөвлөсөн бөгөөд уг үзүүлэлтийг Дэлхийн банкнаас үндсэн 6 шалгуурын хүрээнд тооцож гаргадаг. 2024 оны үзүүлэлт гарах хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй байна. 2023 оны үзүүлэлтээс харахад, 6 үзүүлэлтээр Монгол улсын үнэлгээ гарсан байгаа бөгөөд эдгээр үзүүлэлт нь батлагдсан шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжтэй тохирохгүй байна.

- Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнг Иелийн их сургуулийн судалгаагаар тогтоодог Байгаль орчны гүйцэтгэлийн индекс гэсэн үзүүлэлтээр тодорхойлохоор төлөвлөсөн ба 2024 оны үнэлгээгээр 143 байранд эрэмбэлэгдсэн байгаа нь зорилтот түвшинд хүрээгүй буюу гүйцэтгэл 48.0 хувь байна.

Хүснэгт 11. Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

№	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	Экспортыг нэмэгдүүлнэ.	Экспорт	Тэрбум ам.дол	2022	12.5	13.7	15.8	100.0
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Гадаадын хөрөнгө оруулалт	Тэрбум ам.дол	2021	2.7	4	2.9	15.4
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	Хүний хөгжлийн үзүүлэлт	Эрэмбэ	2021	96	92	96	0.0
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	Хүлээн авах гадаад жуулчид	Тоо (сая)	2022	0.3	1.3	0.73	43.0
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	Хүнсний аюулгүй байдлын индекс	Хувь	2021	53.5	57.6	-	-
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	Хотын хөгжлийн үзүүлэлт	Оноо	2021	0.6	0.6	0.5022	83.7
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж	Эрэмбэ	2021	108	100	-	-
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	Эрэмбэ	2022	155	130	143	48.0

Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээтэй харьцуулж үзэхэд, дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Шалгуур үзүүлэлт ба төсөл, арга хэмжээний биелэлтийн харьцуулалт

Үзүүлэлт	Тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийн тайланг үндэслэж үнэлсэн үнэлгээ	Тэргүүлэх чиглэлд хамаарах арга хэмжээний дундаж үнэлгээ	ХШҮ-ний үзүүлэлтийн хүрсэн түвшин
Нэг. Экспортыг нэмэгдүүлнэ.	78.0	36.5	100.0
Хоёр. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	67.6	50.2	15.4
Гурав. Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	67.5	71.4	0.0
Дөрөв. Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	70.0	45.0	43.0
Тав. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	75.0	78.0	-
Зургаа. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	40.0	59.9	83.7
Долоо. Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	93.3	81.0	-
Найм. Ногоон хөгжлийг дэмжинэ.	72.0	86.3	48.0

Хоёр.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтад төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хүрээнд хамаарах 24 зорилтот үр дүнгийн 29 шалгуур үзүүлэлт тусгагдсан.

Нийт 29 шалгуур үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшний гүйцэтгэл дунджаар 69.4 хувь байгаа бөгөөд 15 үзүүлэлт 100.0 хувь буюу зорилтот түвшиндээ хүрсэн бол 4 үзүүлэлт 50.0-99.0 хувиар, 4 үзүүлэлт 10.0-50.0 хүртэл хувиар, 5 үзүүлэлт 0.0-10.0 хүртэл хувиар тус тус зорилтот түвшингээ хангасан байна. Нэг шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй байна. (Хавсралт 2)

Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцоход зарим үзүүлэлтийн 2024 оны статистик мэдээлэл, тайлан гараагүй байгаа тул өмнөх оны болон 2024 оны эхний хагас жилийн болон 11 дүгээр сарын мэдээллээр хүрсэн түвшинг тооцов. Тухайлбал:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үзүүлэлтээс “Авлигын үзүүлэлтийг сайжруулна”, “Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ” зорилтот үр дүнгийн хүрээнд дэх шалгуур үзүүлэлт буюу Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын индекс, Засгийн газрын үр нөлөөний үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшинг тодорхойлох хугацаа болоогүй тул 2023 оны үзүүлэлтээр тооцов.
- “Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтот үр дүнгийн Цахилгаан эрчим хүчний дотоодоос хангасан хувь гэсэн шалгуур үзүүлэлтийн 2024 оны жилийн эцсийн дүн 2025 оны 5 дугаар сард гарах тул хүрсэн түвшинг 2024 оны эхний хагас жилийн байдлаар авч үзэв.
- “Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” зорилтот үр дүнгийн Цахилгаан эрчим хүчний дотоодоос хангасан хувь гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг 2024 оны 11 дүгээр сарын үзүүлэлтээр авч үзэв.

Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийн зорилтот үр дүн болон шалгуур үзүүлэлт, түүний суурь түвшин, зорилтот түвшинг уялдаатай, оновчтой төлөвлөөгүйгээс үр дүн, хүрсэн түвшинг бодитой тогтоох боломжгүй байна. Тухайлбал,

- “Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.” зорилтот үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг Шүүхийн сахилгын хороонд гаргасан гомдлын тоо гэж алдаатай тодорхойлсон байгаа тул батлагдсан шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшний хүрээнд хүрсэн түвшинг авч үзэв.

- “Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ” зорилтот үр дүнгийн Гол нэр төрлийн 16 хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамж гэсэн шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, зорилтот түвшинг хэт өндөр тодорхойлсон тул хүрсэн түвшинг бодитой тодорхойлох боломжгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд хамаарах төсөл арга хэмжээний биелэлтийн хувьтай харьцуулж үзэхэд, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дундаж 69.4 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд хамаарах төсөл арга хэмжээний биелэлтийн дундаж 62.2 хувь ба дундаж үзүүлэлт 7.2 нэгж хувиар зөрүүтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн 29 шалгуур үзүүлэлтийн үнэлгээг төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд хамаарах төсөл арга хэмжээний биелэлтийн үнэлгээтэй харьцуулахад, 19 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувь нь холбогдох төсөл, арга хэмжээний биелэлтийн хувиас илүү өндөр хувийн зөрүүтэй байгаа ба энэ нь нийт шалгуур үзүүлэлтийн 67.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 13. Үнэлгээний өндөр зөрүүтэй зорилтот үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Зөрүү
1.1.Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Ачаа эргэлт	48.4
1.2.Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Боомтын ачаа нэвтрүүлэх хүчин чадал	64.0
1.4.Гадаад худалдааг хөнгөвчилнө.	Уул уурхайн бус гадаад худалдаа /экспорт/	65.0
2.3.Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Цахилгаан эрчим хүчний дотоодоос хангасан хувь	45.0
2.5.Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангана	52.5
3.3.Өвчлөл, нас баралтыг бууруулна.	10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо	42.5
4.1.Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Шинээр нэмэгдэх аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл	48.0

Мөн 9 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувь нь холбогдох төсөл, арга хэмжээний биелэлтийн хувиас багассан хувийн зөрүүтэй байгаа ба энэ нь нийт шалгуур үзүүлэлтийн 32.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 14. Үнэлгээний багассан зөрүүтэй зорилтот үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Зөрүү
1.3.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт	53.0
2.4.Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	47.9

3.3.Өвчлөл, нас баралтыг бууруулна.	Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	57.5
6.2.Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж	77.5
7.3.Хүний эрхийн зөрчлийг бууруулна..	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол	80.0
8.1.Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	38.3

Шалгуур үзүүлэлт болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд хамаарах төсөл арга хэмжээний хувьд харьцуулах боломжгүй буюу хоорондоо уялдаагүй дараах үзүүлэлтүүд байна.

Хүснэгт 15. Харьцуулах боломжгүй үзүүлэлт

№	Зорилт үр дүн	№	Шалгуур үзүүлэлт	ТЕЗ-ын үр дүнгийн үнэлгээ
3.1	Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	1	Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээ	3.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийн тоог нэмэгдүүлнэ.
		2	Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж	3.1.2.Дээд боловсролын судалгааг эдийн засгийн эргэлтэд оруулна.
		3	Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж	3.1.3.Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна.
		4	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь	3.1.4. Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.
		5	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь /их, дээд сургууль/	3.1.5. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.
3.3	Өвчлөл, нас баралтыг бууруулна.	6	Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	3.3.1. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.
		7	10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо	3.3.2.Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. 3.3.3. Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтад хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд хамаарах 53 зорилтот үр дүнгийн 63 шалгуур үзүүлэлт тусгагдсан.

Нийт 63 шалгуур үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшний гүйцэтгэл дунджаар 56.96 хувь байгаа бөгөөд 18 үзүүлэлт 100.0 хувь зорилтот түвшиндээ хүрсэн, 19 үзүүлэлт 50.0-90.0 хувь, 24 үзүүлэлт 0.0-50.0 хүртэл хувь байгаа бол 2 үзүүлэлт статистик мэдээлэл гарах хугацаа болоогүй ба үнэлэх боломжгүй байна. (Хавсралт 3). Дээр дурдсаны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшингийн зарим үзүүлэлтийн 2024 оны статистик мэдээлэл, тайлан

гараагүй байгаа тул өмнөх оны болон 2024 оны эхний хагас жилийн болон 11 дүгээр сарын мэдээллээр хүрсэн түвшинг тооцсон болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дараах шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн буюу гүйцэтгэл 100.0 хувь байна Үүнд:

1. Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг 60 сая тоннд хүргэнэ.
2. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
3. Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.
4. Авто машингүй зорчих замын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
5. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
6. Эрэн хайх, аврах ажиллагааны чанарыг нэмэгдүүлнэ.
7. Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
8. Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно.

Нийт 63 шалгуур үзүүлэлтийн 24 үзүүлэлтийн хүрсэн түвшин 0.0-50.0 хүртэл хувь байгаа ба энэ нь нийт шалгуур үзүүлэлтийн 38.1 хувийг эзэлж байна. Үүнд дараах зорилт үр дүнгүүдийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ голлон нөлөөлсөн байна:

1. Авто замын сүлжээг өргөтгөнө.
2. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлнэ.
3. Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.
4. Сургуулийн өмнөх боловсролын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.
5. Нислэгийн тоог нэмэгдүүлнэ.
6. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
7. Цэргийн мэргэжил олгох сургалт болон Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.

Харин нийт шалгуур үзүүлэлтээс 2 үзүүлэлт статистик мэдээлэл гарах хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй байна. Тухайлбал, “Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” зорилтот үр дүнгийн “Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалт” шалгуур үзүүлэлтийн суурь судалгааг “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага” гаргадаг бөгөөд энэхүү судалгаа нь 2021 оноос хойш хийгдээгүй тул үнэлэх боломжгүй байна. “Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлнэ” зорилтот үр дүнгийн “Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр нэмэгдүүлэх хувь” шалгуур үзүүлэлтийг тооцох боломжгүй буюу энэ үзүүлэлтийг тооцох аргачлал батлагдаагүй байна.

Хөтөлбөрийн үр дүнгийн 63 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг хөтөлбөрийн үр дүнд хамаарах төсөл арга хэмжээний үнэлгээтэй харьцуулахад, нийт 63 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувийн дундаж 56.96 хувь бол хөтөлбөр арга хэмжээний үнэлгээний дундаж 60.12 хувь буюу зөрүү 3.16 нэгж хувь байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд бодлогын тэргүүлэх 8 чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 24 үр дүн, хөтөлбөрийн 53 үр дүн, 194 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлт тусгагдсан ба төлөвлөгөөний биелэлт дунджаар 57.2 хувь байна. Энэхүү хэрэгжилтийг эхний хагас жилийн үзүүлэлттэй харьцуулахад 15.0 нэгж хувиар өссөн байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 194 төсөл, арга хэмжээний 19.1 хувь буюу 37 төсөл, арга хэмжээ “үр дүнтэй”, 30.9 хувь буюу 60 төсөл, арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 35.1 хувь буюу 68 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 14.9 хувь буюу 29 төсөл, арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 194 төсөл, арга хэмжээг 13.9 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5.1 их наяд төгрөгийг зарцуулсан нь нийт төсөвлөсөн дүнгийн 36.4 хувийг эзэлж байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээний 50.0 хувь буюу 97 арга хэмжээ үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн нь төлөвлөгөөг судалгаа, тооцоололд тулгуурлан үндэслэлтэй боловсруулаагүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилт батлагдаагүй, бэлтгэл, урьдчилсан шатны ажлын явц удаашралтай байгаа зэргээс шалтгаалж байгаагийн зэрэгцээ арга хэмжээний биелэлтийг бүрэн, тодорхой тайлагнаагүйтэй холбоотой байна.

Хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа арга хэмжээний урьдчилсан судалгааг бүрэн хийж, нөхцөл байдал, хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээг зөв тодорхойлоогүй, он дамжин хэрэгжих болон тухайн онд шинээр хэрэгжих арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг үйл ажиллагааны эрэмбэ дараалал, үе шатнаас хамааруулан оновчтой төлөвлөөгүй, мөн төлөвлөгөөний төслийг дээд шатны байгууллагад өргөн барихаас өмнө бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудад танилцуулж эцэслэн тохироогүйгээс төлөвлөгөөнд хэрэгжих боломжгүй арга хэмжээ нэмж тусгагдсан зэргээс шалтгаалан зарим төсөл, арга хэмжээний биелэлт хангагдахгүй байна.

Түүнчлэн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, төсөл арга хэмжээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг харилцан уялдаатай төлөвлөөгүй, үр дүн, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн нийцэл хангагдаагүй, шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, зорилтот түвшин тодорхойлоогүй зэрэг төлөвлөгөөтэй холбоотой дутагдалтай асуудлууд байгаа нь хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэл үүсгэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг 8 чиглэл, 23 зорилт, 39 дэд зорилттойгоор баталсан нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний агуулгатай давхардсан, мөн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээ нь хөтөлбөрийн үр дүнг, хөтөлбөрийн үр дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн нь тэргүүлэх чиглэлийн үр дүнг хангаж байгаа эсэх нь тодорхойгүй буюу шууд харьцуулан үнэлэх боломжгүй байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-ийн 18 үр дүнг хоёрдугаар хавсралтаар баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгалгүй орхигдуулсан, мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд нэгдүгээр хавсралтаар батлаагүй 33 үр дүнг тусгаж баталсан, мөн хоёрдугаар хавсралтаар баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 6 үр дүнг гуравдугаар хавсралтад агуулгыг өөрчлөн томьёолсон, мөн хоёрдугаар хавсралтаар баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 27 үр дүн, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг оновчтой бус, алдаатай тодорхойлсон зэрэг төлөвлөлтийн алдаатай асуудал байна.

Мөн дээрх тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг баталж, тогтоолын хоёрдугаар хавсралтаар дээрх нэгдүгээр хавсралтад дурдсан тэргүүлэх чиглэлийг хангах төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ гэсэн хэлбэрээр баталсан ба энэ нь тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний давхардлыг бий болгож байна.

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн биелэлтийг төрийн байгууллагуудаас ирүүлсэн тайлан мэдээлэлд үндэслэн үнэлсэн ба энэхүү үнэлгээг тэргүүлэх чиглэлд хамаарах арга хэмжээний дундаж үнэлгээ болон тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үзүүлэлттэй харьцуулахад, тэргүүлэх чиглэлд хамаарах арга хэмжээний дундаж үнэлгээнээс 3.0-41.5 хүртэл хувиар, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үзүүлэлтээс 2.0-71.4 хүртэл хувиар зөрүүтэй байгаа нь төлөвлөлт, тайлагналтаас шалтгаалж байгаагийн зэрэгцээ төсөл арга хэмжээний биелэлт, хөтөлбөрийн, төсвийн ерөнхийлөн захирагчийн, тэргүүлэх чиглэлийн үр дүнг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтээр шууд илэрхийлэхэд учир дутагдалтай байна.

Цаашид Монгол Улсын тухайн жилд баримтлах тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт хоорондын уялдаа холбоо, нийцлийг хангаж, бодлогын баримт бичгийг боловсруулж баталж байх шаардлагатай байна.

ТАВ. САНАЛ

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Эдийн засаг, хөгжлийн яам:

1.1. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нөхцөл байдлын дүн шинжилгээ, тухайн үйл ажиллагааны эрэмбэ дараалал, гүйцэтгэх үе шатанд тулгуурлан оновчтой, зөв тодорхойлж, төлөвлөх;

1.2. Тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн нийцлийг хангах;

1.3. Монгол Улсын төсөв батлагдсаны дараа жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тодотгол хийдэг байх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

1.4. Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх;

Хоёр. Сангийн яам:

2.1. Зураг төсөл, магадлал хийгдсэн барилга, байгууламж барих арга хэмжээг улсын төсөвт тусгадаггүйн улмаас магадлалын хүчинтэй хугацаа дуусч, мөн дахин магадлуулах шаардлага үүсэж төсвийн үр ашиггүй зарцуулалт гарч байгааг зогсоох арга хэмжээ авах;

2.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн арга хэмжээ бүрээр төлөвлөсөн төсөв, санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг улирал тутамд нэгтгэн бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудад хүргүүлдэг байх арга хэмжээг зохион байгуулах;

Гурав. Төсвийн ерөнхийлөн захирагч нар:

3.1.Хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн явцад байнгын хяналт тавьж, биелэлт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангах;

3.2.Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан шатны бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянах, тендер шалгаруулалт, гэрээ хэлцэл хийх зэрэг ажлыг шуурхай зохион байгуулах, энэ чиглэлээрх мэргэжлийн байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны процессыг сайжруулах.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай дараах (QR) кодоор нэвтрэн танилцана уу.



----- оОо -----